

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно үү.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Монгол улсын Үндэсний их баяр наадмын тухай хууль болон холбогдох бусад хуульзүйн актуудад заагдсан зөвшөөрөгдсөн насанд хүрсэн хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд нь энэхүү даатгалын зүйл байна.					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Улсын болон орон нутгийн шинж чанартай морины уралдаан, түүний бэлтгэл, сунгааны үеийн бүх төрлийн гэнэтийн осол гэмтэл 2. Байгалийн эрсдэл /хүчит салхи цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нурулт, гулгалт, цөмрөлт, аянга, хээрийн түймэр/ 3. Ахуйн эрсдэл /юманд цохиулах, хавчигдах, хавчуулах, хальтрах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох, наранд цохиулах, угаартах, хоол, хорт хий, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан шавьжинд өртөх, зам тээврийн осолд өртөх/ 4. Мал маллагаа, амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл /мал, амьтнаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах/ 5. Техниктэй харьцах үеийн эрсдэл /Автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг осол/					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.5%					

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ**

1. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу хохирол гарч болох орчин нөхцөлийг бүрдүүлсэн;
2. Даатгагдагч уралдааны замд хамгаалалтын иж бүрэн хувцас өмсөөгүй;
3. Даатгуулагч хуурч мэхэлсэн болон даатгуулагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
4. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн буюу нөхөн төлүүлэхээр шүүхээр шийдвэр гарсан;
5. Даатгуулагч, түүний гэр бүлийн гишүүд, ойрын садан төрлийн хүмүүсийн санаатай үйлдэл нь хохирол гарах шалтгаан болсон нь хуулийн байгууллагаар тогтоогдсон;

6. Даатгуулагчийн эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, хууль дүрмийг ноцтой зөрчсөн;
7. Монгол улсын хууь тогтоомжид заасан бусад үндэслэл